

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 11 / 18.8 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ДААЛГАВАР

НЭГ.ҮНДЭСЛЭЛ:

1.1. Гэр бүлийн тухай хуулийн 14.1, 14.2-д “Шүүх шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд, гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна. Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэхэд авах бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

1.2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Шүүхийн ерөнхий зөвлөлтэй 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан “Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл зүйч, шинжээчийн дэмжлэг үзүүлэх тухай” санамж бичгийг хэрэгжүүлэх хүрээнд Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газарт 2 сэтгэл зүйчийг гэрээлэн ажиллуулна.

ХОЁР.ЗОРИЛГО:

2.1. Гэр бүлийн маргаан шийдвэрлэх явцад гэрлэгчдийн сэтгэлзүйн байдалд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, эвлэрэлд хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, сэтгэл хөдлөлд тулгуурласан шийдвэрээс сэргийлэх, эвлэрсэн гэр бүлийн тоог нэмэгдүүлэх.

ГУРАВ.ХИЙХ АЖЛЫН ХҮРЭЭ:

3.1. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газарт 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаанд 7 хоногийн 5 өдөр 40 цагаар ажиллаж, дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

3.1.1. Эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд дараах чиглэлээр оролцно:

3.1.1.1 Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх /Гэр бүл, стресс, сэтгэл гутрал түгшүүр зэрэг сэтгэл зүйн асуудалтай иргэдэд чиглэл өгч, асуудлыг даван туулах аргыг зааж, чиглүүлэх/

3.1.1.2 Талуудын сэтгэл зүйн байдлыг урьдчилан үнэлэх /Ярилцлага, асуулга, сорилын аргаар хувь хүний сэтгэл зүйн байдал зан төлөв, сэтгэл хөдлөлийг судлах/

3.1.1.3 Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад амжилтгүй болсон буюу эвлэрээгүй гэрлэгчдэд хүүхдийн сэтгэл зүй, санхүү, боловсрол, хүмүүжлийн тал дээр эцэг эхийн үүрэг хариуцлагыг ухамсарлахад сэтгэл зүй дэмжлэг үзүүлэх

3.1.1.4 Эвлэрүүлэн зуучлагчид мэргэжлийн зөвлөмж өгөх

3.1.2. Гэр бүл цуцалтын үндсэн шалтгаан нөхцөлийг судлах /Тухайн шүүхэд ирж байгаа иргэдийн сэтгэл зүй, зан төлөвийн талаар судалгаа хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй аргачлал/

3.1.3 Сэтгэл зүйн боловсрол олгох /Тухайн шүүхийн нутаг дэвсгэрт байрлах иргэдэд явцаруулж зуучлагч нартай хамтран сэтгэл зүйн боловсрол, зан дадап хэвшиүүпэхэд чиглэсэн сургалт, лекц зохион байгуулах/

3.1.4. Сэтгэл зүйч нь шаардлагатай тохиолдолд хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн аргаар түүний байр суурь, сэтгэлзүйн хэрэгцээг тодорхойлж шүүхэд зөвлөмж өгнө.

3.1.5. Хүүхдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах үед түүний сэтгэл зүйн хувьд дэмжлэг үзүүлнэ.

ДӨРӨВ. ТАВИГДАХ ШААРДЛАГА:

4.1. Сэтгэл судлаач мэргэжлээр их дээд сургууль төгссөн (гэр бүлийн сэтгэлзүйн чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно)

4.2. Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай

4.3. Гэр бүлийн зөвлөгөө өгөх ур чадвартай,

4.4. Гэмт хэрэг зөрчилд холбогдож байгаагүй

4.5. Хувийн зохион байгуулалт сайтай, цаг баримталдаг

4.6. Багаар ажиллах, харилцааны өндөр соёлтой

4.7. Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй, бичгийн болон аман илтгэх ур чадвартай

ТАВ. ТӨСӨВТ ӨРТӨГ:

5. 2 сэтгэл зүйч 30,000,000 (гучин сая) төгрөг.

---oOo---